

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН 6-Р БАГИЙН 31 АЙЛЫН  
НИЙТИЙН ОРОН СУУЦНЫ ДУНДЫН ЭЗЭМШЛИЙН ДУЛААНЫ ШУГАМ  
ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

**Тендер шалгаруулалт: Сайншанд сумын 6-р багийн 31 айлын нийтийн орон сууцны  
дундын эзэмшилийн дулааны шугам өргөтгөл шинэчлэлийн ажил  
Гэрээний нэр, дугаар: ОНТХО-ХА-21/2019**

**Сайншанд хот  
2019 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019-02-20

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сайншанд сумын б-р багийн 31 айлын нийтийн орон сууцны дундын эзэмшилийн дулааны шугам өргөтгөл шинэчлэлийн ажил”-ыг гүйцэтгэх цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2019 оны 02-р сарын 28**-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө **тендерийн материалыг tender.gov.mn сайтаар ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 02 сарын 28**-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

**Дотоодын давуу эрх тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорноговь аймаг Сайншанд хот 3-р баг нутгийн удирдлагын ордон 1 давхар 106 тоот  
Утас:7052-2224 Факс:7052-0004**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
    - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
    - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
    - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3. Тендерийн иж бүрдэл**
    - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
      - (a) *Үнийн санал;*
      - (b) *Оролцогч компанийн танилцуулга*
      - (в) *Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг; /санхүүгийн тайлан, туршилагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар / болон бусад баримт бичиг/*
      - (д) *Ижил төрлийн ажил, үйлчилгээ үзүүлсэн туршилага гэрээ холбогдох тайлангийн хуулбар;*
      - (е) *Шаардлагатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар*  
*Барилга угсралтын ажлын 2.2.1 -/ БА.6.2, БА.7.2/ заалт бүхий хугацаа дуусаагүй тусгай зөвшөөрөл.*
      - (ё) *Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар*
- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл*
- Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх*
- Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх*
- Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчиний чадвар, туршилагын талаарх мэдээлэл*
- Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршилагын мэдээлэл*
- /Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш өдрөөр ирүүлэх./*
- 4. Тендерийн үнэ**
    - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
    - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал

болгож болно.

- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

**5. Үнийн  
саналын  
хүчинтэй  
байх  
хугацаа**

**6. Алдааг  
залруулах**

**7. Санал  
болгосон  
үнэ,  
түүнийг  
үнэлэх**

**8. Гэрээ**

- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
  - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах

**байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл**

эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН  
ХҮСНЭГТ**

ТОӨЗ-НЫ ХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн санхүүгийн тайлан 2018 он /аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн [1] туршлагын мэдээлэл 2018 он /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хуулбар/</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p><b>Барилга угсралтын ажлын 2.2.1 - /БА.6.2, БА.7.2/ заалт бүхий хугацаа дуусаагүй тусгай зөвшөөрөл.</b></p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <p><i>/Тендер зарлагдсанаас хойши он, сар, одроог ирүүлэх./</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар</li> <li>- Оролцогч компанийн танилицуулга</li> <li>- Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар /гэрээ болон хавсралтын хамт/</li> <li>- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх нотлох баримт бичиг</li> <li>- Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх</li> </ul> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай.</p> <p><b>Ачааны автомашин, нивелир, лазер тэгши ус, рейк, цахилгааны төрөл бүрийн багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх, барилгын засал чимэглэлийн гар багаж хэрэгсэл, шат вандан холбоос, бусад шаардлагатай тоног төхөөрөмжээ гэх мэт.</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: tender.gov.mn</p> <p><b>Сайншанд сум, 3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>1 давхар 106 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>

ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b><i>Сайншанд сум, 3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон</i></b>          Давхар болон өрөөний дугаар: <b><i>1 давхар 103 тоот</i></b>          Огноо: <b><i>2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр</i></b>          Цаг: <b><i>10 цаг 30 минут</i></b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b><i>“Сайншанд сумын 6-р багийн 31 айлын нийтийн орон сууцны дундын эзэмшилийн дулааны шугам өргөтгөл шинэчлэлийн ажил”</i></b></p>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



Дорноговь аймгийн Сайншанд сумын 6 дугаар багийн 31 айлын нийтийн орон сууцны дундын эзэмшлийн дулааны шугам өргөтгөн шинэчлэх ажил:

*A.* Ажил гүйцэтгэх хугацааны график/ хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчиний тоо/-ийг тодорхой гаргажс ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

*B.* Гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээ, Ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

### 1. Гадна дулааны шугамын угсралтын ажил

Орон сууцны хорооллын гадна дулааны шугамын ажлыг гүйцэтгэхдээ Гадна дулаан хангамж БНБД 41-02-13, Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНБД 41-04-13-г тус тус баримтална.

Дулааны шугамын холболтын ажлыг хийхдээ хангагч байгууллагаас өгөгдсөн техникийн нөхцлийн дагуу одоо байгаа ДХ№1 худгаас ДХ№6 хүртэл дулааны шугамыг өргөтгөж ф100 мм-ийн голчтой ган хоолойгоор холболт хийнэ. ДХ№1,5, 6 худгуудыг шинээр бетон цутгаж хийнэ. Яндан хоолойн агшилт суналтанд сальникан компенсаторыг угсарна.

Яндан хоолойн угсралтын үед гадны хог шороо, бохирдлоос цэвэрлэж, зэврэлтээс хамгаалах түрхлэг түрхэн дулаалгыг хийж өгнө.

Яндан хоолойн дулаалгын материалыг пенопласт болон пенополиуратан материалыар сонгоно. Дулаалгын гадуур хамгаалах бүрхүүлийг хийж өгөх хэрэгтэй. Ган яндангийн дулаалгын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 41-04-13-г баримтлана.

Дулааны шугамыг угсралдаа угсралтын норм дүрмийн дагуу гүйцэтгэж зохих даралтаар шалгах хэрэгтэй.

Ус дамжуулах шугамын доод цэгт юулэх, дээд цэгт хийн хаалтыг угсарч өгнө.

Гулсах тулгуур хоорондын зайд нь 80 мм-ийн голчтой шугамд 3.5 м, 100 мм-ийн голчтой шугамд 4 м, 125мм-ийн голчтой шугамд 7 м тус тус байна.

Одоо байгаа дулааны шугам нь дэвсгэр зургийн өндрөөс харахад ДХ№6 худгаас ДХ№1 худаг тийш налуу байгаа тул ДХ№6 худаг дээр хий авагч, ДХ№1 худаг дээр таслах хаалт юулэгч угсарч өгнө.

**Төндөрт шалгарсан гүйцэтгэгч нь:** Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлыг гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг

хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ лабораторын шинжилгээний дүн, падаан хавсаргана.

-Гадна дулааны шугамын угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

-Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 14.3 заасны дагуу ашиглалтанд өгснөөс хойш зүгшрүүлэх, тохишуулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доoshгүй жил байна.

-Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

-Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

-Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлага зэргийг биелүүлнэ.

-Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацааг зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

-Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “IY” 81-95-12-г мөрдлөг болгоно.

-Автотээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

-ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмыг зардлыг тооцож ирүүлнэ.

-Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

**САЙНШАНД СУМЫН 6-Р БАГТ БАЙРЛАХ ЗИ АЙЛЫН НИЙТИЙН  
ОРОН СУУЦНЫ ДУНДЫН ЭЗЭМШЛИЙН ДУЛААНЫ ШУГАМ  
ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

***Дугаар 1***

**2019.01.22**

<b>1. Зураг төсөл зохиох үндэслэл</b>	2019 оны Улс хөрөнгө төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
<b>2. Барилга байгууламжийн байршил, чиглэл</b>	Дорноговь аймаг, Сайншанд сум,
<b>3. Зориулалт, хүчин чадал</b>	Иргэдийг дулааны эрчим хүчээр найдвартай хангах. Гадна дулааны ган хоолой 100мм-414м, хаалт армотур-14ш, 3ш дулааны худаг тус тус хийнэ.
<b>4. Үйлдвэрлэлийн технологи (үйлдвэрлэлийн барилгад-Техник технологийн дэвшилтэд болон байгаль экологийн тэнцвэрийг хадгалах, хаягдалгүй технологи ашиглах зэрэг нөхцөл)</b>	
<b>5. Хэрэглэгчийн ачаалал</b>	31 айлын дулааны ачааллыг хангахуйц 100мм диаметртэй ган хоолойгоор угсрах
<b>6. Ажиллах горим(үйлдвэрлэлийн барилгад)</b>	Дулааны температурын горим, өгөх/буцах 95/70 градус
<b>7. Үйлдвэр аж ахуйн газар, барилга байгууламжийн бүрэлдхүүн</b>	Дулааны шугам, үзлэгийн худаг, одоо байгаа хэрэглэгчдийн гаргалгааны холболт
<b>8. Барилгын үндсэн бүтээц, материал</b>	Ган яндан хоолой.
<b>9. Зураг төслийн бүрэлдэхүүн (Баир зүйн дэвсгэр зураг, инженер геологийн дүгнэлт, байгаль экологийн дүгнэлт зэрэг тухайн барилгын төлөвлөлтийн онцлогтой уялдсан бусад дүгнэлт, судалгаа, төсөөв зэрэг зургийн бүрдэлд хамрагдах ажлыг бичнэ)</b>	1. Дэвсгэр зураг 2. Ажлын зургийн бүрдлүүд 3. Төсөөв
<b>10. Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийц, цаашид өргөтгөх</b>	100мм ган хоолой нь 4мм зузаан ханатай байх.
<b>11. Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр (дулаан, усан хангамж ариутгах татуурга, цахилгаан, холбоо, инженерийн хангамж)</b>	Дулааны станцаас
<b>12. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай зам, тээвэр(кран, лифт гэх мэт)</b>	Байхгүй
<b>13. Зургийн үе шат, хугацаа</b>	

<b>14. Зураг төслийн байгууллага</b>	
<b>15. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага</b>	
<b>16. Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)</b>	
<b>17. Галын аюулгүй байдлын нөхцөл</b>	
<b>18. Байгаль орчны үнэлгээ</b>	
<b>19. Эдийн засгийн тооцоо, төсөв</b>	Төсвийг estimator pro программ ашиглан гүйцэтгэнэ

БОЛОВСРУУЛСАН. М.МОНХБАЯСГАЛАН

## ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендериийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх   |

эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүргэл сунгана.

**10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

**11. Үе шатны ажлын хуваарь**

- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

**12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**

- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

**13. Алданги**

- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## G. ГЭРЭЭГ ДУУСГАХ

**14. Ажил дуусгах**

- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

**15. Хүлээж авах**

- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

## 16. Эцсийн тооцоо

- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

## 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

## 18. Гэрээг цуцлах

- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд засан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>**

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>OHTXO-XA-21/2019</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь “ <i>Сайншанд сумын б-р багийн 31 айлын нийтийн орон сууцны дундын эзэмшилийн дулааны шугам өргөтгөл шинэчлэлийн ажил</i> ”-аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>Сайншанд суманд байршина</i> .
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: АЗДТГХОХБХ мэргэжилтэн М.Мөнхбаясгалан
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <b>2019-04-01</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>2019-06-01</b>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [ <b>ажлын 5</b> ] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа: <i>Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу туршилт тохицуулга 12 сар, 14.6-д заасныdagуу 36 сарын баталгаа гаргаж өгнө. Барилга угсралтын ажилд шаардагдах гол нэр төрлийн материалын дээжийг итгэмжлэгдсэн барилгын материалын сорилт шинжилгээнд хамруулна.</i> <sup>4</sup>
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.1 хувь] байна. <sup>4</sup> Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2019/06/01]-ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [2019/06/01]-ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [ <b>500000 төгрөг</b> ] байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [0.1 хувь]-иар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### ЗӨВШӨӨРСӨН

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “түйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий  
\_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь,  
хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_  
барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам  
сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад  
ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр  
ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]